



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

**ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
СУДАЛГААНЫ БҮТЭЭЛ БҮРДҮҮЛЭХ ХЭРЭГЛЭГЧИЙН ЗААВАР
ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН СУДАЛГААНЫ
МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН (MUST-RIS) АНГИЛАЛ**

Зохиогч ШУТИС-ийн Эрдмийн Замналын Тогтолцооны Загвар (MUST-ATTM)
Огноо: 2023 оны 10 сар

Table of Contents

Эрдэм шинжилгээний бүтээлийн төрлүүд.....	3
1.1. Эрдэм шинжилгээний бүтээлийн ангиллууд:.....	3
1.2. Эрдэм шинжилгээний бүтээлийн мэдээлэл цуглуулах	4
1.3. Эрдэм шинжилгээний бүтээлийн нотлох баримт цуглуулах	4
1.4. Гадаад хэл дээрх эрдэм шинжилгээний бүтээлүүд	4
1.5. ERM-н шаардлагыг хангаж буй эсэхийг үнэлэх	5
1.6. MRIS-д судалгааны бүтээлийг оруулах	5
1.7. Шаардлагатай бол зохиогчийн харьяалагдах байгууллагын мэдэгдлийг цуглуулах	5
1.8. Судалгаа үйлчилгээний ажилтнуудын (RSD) хүсэлтэд хариу өгөх	5
2. ERM-т тавигдах шаардлага.....	5
2.1. ERM-ийн шалгуур үзүүлэлт:	5
2.2. Судалгааны тодорхойлолт	6
2.3. Хэвлэгдсэн он	7
2.4. Зохиогчийн харьяалагдах байгууллага	7
2.5. Чанарын хэмжүүрүүд	7
2.6. Арилжааны зориулалттай хэвлэлийн газар	8
2.7. Хянан магадлагаа	8
2.8. Цахим бүтээлүүд.....	8

Оршил

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль (ШУТИС) нь ажиллагсад, оюутнууд болон түр хугацаагаар ажиллах эрдэмтдийн гаргасан олон төрлийн судалгааны үр дүнгийн талаар мэдээлэл цуглуулна. ШУТИС цуглуулсан өгөгдлөө менежментийн тайлан, төсвийн таамаглал, дотоод үнэлгээ, ШУТИС-ийн судлаачын вэб сайт, академик сурталчилгаа, сургуулийн жил тутмын тайлан болон салбарын вэб сайтад байршуулах зэрэг олон зорилгоор ашиглана.

Монголын шилдэг судалгаа (Excellence in Research for Mongolia-ERM) судалгааны өгөгдөл цуглуулах хөтөлбөр. Судалгааны бүтээлийн тухай мэдээллийг вэбд суурилсан өгөгдлийн сан болох MRIS-д бүртгэнэ. Бүх эрдэм шинжилгээний бүтээл ERM-н шаардлагыг хангах эсэхээс үл хамааран MRIS-д бүртгүүлэх ёстой. Энэхүү хэрэглэгчийн заавар нь янз бүрийн хэвлэлийн ангилалын кодчилол болон ERM-д орох эрдэм шинжилгээний бүтээлд тавигдах шаардлагыг тайлбарласан болно.

Эрдэм шинжилгээний бүтээлийн төрлүүд

ШУТИС-д эсвэл өөр газар хийгдсэн эсэхээс үл хамааран бүх судалгааны ажлын үр дүнг мэдээллийн санд цуглуулдаг. Эрдэм шинжилгээний бүтээлийг төрлөөр нь (ангилал гэж нэрлэх) болон гол судалгааг хаана хийснээр нь ангилна.

1.1. Эрдэм шинжилгээний бүтээлийн ангиллууд:

1. Ном
2. Номын бүлэг
3. Мэргэжлийн сэтгүүлийн өгүүлэл
4. Хурлын өгүүлэл
5. Иш татсан бүтээл (тулгуур ажил)
6. Компьютерын програм хангамж
7. Нээлт
8. Бүтээлч ажил
9. Тайлан
10. Орчуулга
11. Хууль зүйн хэрэг
12. Газрын зураг
13. Сонин/сэтгүүлийн нийтлэл

14. Төгсөлийн ажил, диплом

15. Дуу, дүрсэт материал

Судалгааны сургууль, төвүүдийн мэдээлэл цуглуулах ажилтнууд өгөгдөл цуглуулах ажлыг дараах байдлаар хариуцдаг.

1.2. Эрдэм шинжилгээний бүтээлийн мэдээлэл цуглуулах

Эрдэм шинжилгээний бүтээл цуглуулах ажилтнуудын хэлтсийн үүрэг бол бүх ажилтан, оюутнууд, зочин эрдэмтдийн бүтээл ШУТИС-ийн эрдэм шинжилгээний бүтээлийн санд (MRIS) оруулсан эсэхийг баталгаажуулах юм. Эрдэм шинжилгээний бүтээлийн мэдээллийг олон эх сурвалжаас авах боломжтой. Судалгаа үйлчилгээний хэлтэсийн (RSD) ажилтнууд арилжааны зориулалттай өгөгдлийн сангаас эрдэм шинжилгээний бүтээлийн мэдээллийг авч тогтмол байршуулна. ШУТИС-ийн бусад хамтын ажиллагаатай хэлтэс нэгжийн ажилтнууд эрдэм шинжилгээний бүтээлийг сан руу мөн нэмнэ. MRIS-д ороогүй нэмэлт эрдэм шинжилгээний бүтээлүүдийн тухай мэдээллийг цуглуулдаг. Ажилтан, оюутан, түр хугацаатай ажиллах эрдэмтэн судлаачдад өөрсдийн судалгааны бүтээлээ тайлагнаж байх шаардлага болон хэрхэн хийх механизмыг нь тогтмол сануулдаг. Мэдээллийн бусад эх сурвалжууд нь Скопус (Scopus), WoS, Trove, ШУТИС-ийн ePress болон ШУТИС-ийн номын сан юм.

1.3. Эрдэм шинжилгээний бүтээлийн нотлох баримт цуглуулах

Эрдэм шинжилгээний бүтээл болон түүний дагалдах баримт бичгийн цахим хувилбарыг бүрдүүлдэг. Ингэхдээ вэб сайтаас татаж авах эсвэл цаасан хуулбарыг сканнердэж баримтуудыг pdf форматаар хадгална. Ангилал тус бүрт шаардагдах нотлох баримт эсвэл баталгаажуулах материалыг энэхүү зааврын дараах хэсгүүдэд жагсаасан болно. Энэхүү нотлох баримтыг MRIS-д оруулсан байдаг.

1.4. Гадаад хэл дээрх эрдэм шинжилгээний бүтээлүүд

Гадаад хэл дээрх эрдэм шинжилгээний бүтээлүүд ч ERM-д хамрагдах боломжтой. Англи хэл дээрх болон бусад эрдэм шинжилгээний бүтээлтэй адилхан нотлох баримт шаардлагатай. Эрдэм шинжилгээний бүтээлийг бүхэлд нь орчуулах шаардлагагүй гэхдээ мэдээлэл нь нэхэмжилж буй ангиллын шалгуурыг хангаж байгааг нотлохын тулд мэдээллийг шалгахад шаардлагатай бүх холбогдох хэсгийг орчуулах ёстой. Үүнд тухайн ажил нь судалгааны тухай тодорхойлолтод нийцэж байгааг нотлох баримтууд орно.

1.5. ERM-н шаардлагыг хангаж буй эсэхийг үнэлэх

Судалгааны бүтээл бүрийг үнэлж, ERM-ын үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхийг тодорхойлно. Аливаа асуудал, тодруулга авахаар publications.collection@must.edu.mn хаягаар судалгааны үйлчилгээний хэлтсийн (RSD-Research Services Division) ажилтнуудтай холбогдно. RSD вэб сайтын судалгааны бүтээлийн хэсэг болох <http://researchservices.must.edu.mn/ore/publications/> хэрэгтэй эх сурвалж, мэдээллийн шинэчлэлтүүдийг агуулна. Ангилал тус бүрийн шалгуурыг хангах дүрмийг энэхүү зааврын доорх хэсгүүдэд жагсаасан болно.

1.6. MRIS-д судалгааны бүтээлийг оруулах

MRIS мэдээллийн санд байхгүй судалгааны бүтээлийг оруулах бөгөөд дахин оруулах бол нэмэлт шаардлагатай мэдээллийг л нэмж оруулна.

1.7. Шаардлагатай бол зохиогчийн харьяалагдах байгууллагын мэдэгдлийг цуглуулах

Зохиогчид ERM-н шаардлагыг хангахын тулд ШУТИС-д харьяалалтай байх ёстой. Зохиогчийн харьяалагддаг байгууллыг хэвлэгдсэн бүтээл дээр ихэвчлэн зааж өгсөн байдаг. Хэрэв судалгааны бүтээл дээр харьяалагддаг байгууллага нь бичигдээгүй бол зохиогчид "харьяа байгууллагын мэдэгдэл"-ийг бөглөж цахим гарын үсэг бүхий и-мэйлээр харьяа байгууллагаа баталгаажуулах шаардлагатай.

1.8. Судалгаа үйлчилгээний ажилтнуудын (RSD) хүсэлтэд хариу өгөх

RSD ажилтнууд судалгааны бүтээлийн талаар нэмэлт мэдээлэл авах хүсэлт гаргаж болно. Аль болох хурдан хариу өгнө үү. Салбар, хэлтэсийнхээ судалгааны бүтээлийн жагсаалтыг тогтмол хүлээн авч, бүрэн бүтэн, үнэн зөв эсэхийг шалгахын тулд ажилтнууддаа тарааж болно.

2. ERM-т тавигдах шаардлага

2.1. ERM-ийн шалгуур үзүүлэлт:

- Тухайн бүтээл өмнө нь хэвлэгдээгүй өөрсдийн санаанд тулгуурлан хийсэн шинжлэх ухааны судалгаа байх ёстой,
- Тухайн бүтээл мэдээллийн санд оруулж буй хуанлийн жилд хэвлэгдсэн байх ёстой,
- Зохиогч/зохиогчид судалгаа хийгдээд хэвлэгдэхээр болох үед ШУТИС-д харьяа байгууллагаа мэдэгдэх ёстой.

- Тухайн бүтээл/ажил нь нэгээс олон ангилалын шаардлагыг хангасан байсан ч ERM-д зөвхөн нэг удаа тооцогдох болно.

2.2. Судалгааны тодорхойлолт

Судалгаа нь шинэ үзэл баримтлал, арга зүй, ойлголтыг бий болгохын тулд шинэ мэдлэг бий болгох буюу эсвэл одоогийн байгаа мэдлэгийг шинэ, бүтээлч байдлаар ашиглах гэж тодорхойлогддог. Үүнд өмнөх судалгааг нэгтгэх, дүн шинжилгээ хийх замаар шинэ, бүтээлч үр дүн гаргахаар өргөтгөхийг багтааж болно. Судалгааны энэхүү тодорхойлолт нь цэвэр ба суурь судалгаа, хэрэглээний судалгаа, туршилт хөгжүүлэлт зэргийг өөртөө агуулсан тодорхойлолт юм.

Хэрэглээний судалгаа нь шинэ мэдлэг олж авахын тулд хийгдсэн анхдагч судалгаа боловч тодорхой, практик зорилго эсвэл зорилгод чиглэсэн байдаг.

Судалгааны үйл ажиллагааг дэмжих, улмаар судалгааны тодорхойлолтод нийцэх үйл ажиллагаанууд нь

- Судалгаа явуулахад шаардлагатай үйл ажиллагаанд шууд оролцдог мэргэжлийн, техникийн, захиргааны болон бичиг хэргийн туслах ажилтнууд
- Судалгааны ажилд шууд оролцох эсвэл тэдгээр ажилтнуудад мэргэжлийн, техникийн, захиргааны болон бичиг хэргийн дэмжлэг үзүүлж, тусалцаа үзүүлж байгаа ажилтнуудын менежмент удирдлага
- Элссэн HDR (HDR-Higher Degree by Research) оюутнуудын сургалт, идэвхжүүлэлт
- HDR сургалт, курсуудыг хөгжүүлэх
- HDR сургалт, курсэд хамрагдаж буй оюутнуудыг удирдаж чиглүүлэх
- Хэрэглээний програм хангамж, шинэ програмчлалын хэл, шинэ үйлдлийн системд судалгаа туршилтын хөгжүүлэлт хийх.

Судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэхгүй хасах шаардлагатай үйл ажиллагаанууд:

- Шинжлэх ухаан, техникийн мэдээлэл үйлчилгээ
- Ерөнхий зориулалттай буюу тогтмол хийгддэг өгөгдөл цуглуулах
- Стандартчилал болон байнгын тогтмол шалгалт
- Биелэлт, гүйцэтгэлийн судалгаа (судалгаа, туршилт хөгжүүлэлтийн төслөөс бусад)
- Төрөлжсөн байнгын эмнэлгийн тусламж үйлчилгээ
- Патент, зохиогчийн эрх, лицензийн үйл ажиллагааны арилжаа, хууль эрх зүйн болон захиргаадалтын байдал

- Өдөр тутмын компьютерын програмчлал, системийн ажил эсвэл програм хангамжийн ашиглалт үйлчилгээ

2.3. Хэвлэгдсэн он

Судалгаа нь тухайн ERM жилд хэвлэгдсэн байх ёстой. **Хэвлэгдсэн огноо эсвэл нотлох баримт нь хүсэлт гаргаж байгаа ажлын дотор эсвэл дээр байх ёстой.** Зохиогч, редактор, зохион бүтээгчээс ирэх захидалд тухайн ажлыг тодорхой нэг онд хэвлэгдсэн гэсэн байсан ч тухайн эрдэм шинжилгээний бүтээлд тийм огноо байхгүй бол хэвлэгдсэн оны баталгаа болохгүй.

Хурлын өгүүллийн хэвлэгдсэн оныг хурал болсон жилд биш хурлын эмхэтгэлд хэвлэгдсэн он дээр үндэслэнэ. CD-Rom дээр хэвлэгдсэн эсвэл вэбэд суурилсан хугацаа тавигдаагүй сэтгүүлийн өгүүлэл, хурлын өгүүлэл үүнд тооцогдохгүй. Энэ тохиолдолд сэтгүүлийн редактор эсвэл хурал зохион байгуулагчаас хэвлэгдсэн оныг тодорхойлж өгсөн захидлыг хүлээн авч болно. Энэ нь зөвхөн хүсэлт гаргаж буй ажилд огноо байхгүй бүтээлүүдэд хамаарна. Редактор эсвэл хурал зохион байгуулагчийн захидал нь ажлын доторх огноог өөрчилж болохгүй. Судалгааны бүтээлийн хэвлэгдсэн он нь ихэвчлэн нэрлэсэн жилийн эхээр, хэвлэгдсэнийг илэрхийлэх онд, цаасаар хэвлэгдсэн буюу зохиогчийн эрх авсан онуудаар байдаг.

2.4. Зохиогчийн харьяалагдах байгууллага

Судалгааны байгууллагын харьяаллыг дараах аргуудын аль нэгээр тодорхойлох ёстой.

- Хүсэлт гаргаж байгаа бүтээл дээр эсвэл дотор нь эсвэл
- Тухайн бүтээлд байгууллагын харьяалал тодорхойлогдоогүй бол их сургууль нь тухайн их сургуулийн ажилтан эсвэл оюутны хувьд судалгааны бүтээлийг хэвлүүлэхүйц судалгааг хийсэн тухай зохиогчоос мэдүүлэг авах ёстой.

Судалгааны бүтээл дээр зохиогч нь нэгээс олон байгууллагад харьяалагддаг болохыг бичсэн байгаа тохиолдолд (тухайлбал, Жанет Харви, Х их сургуулийн эдийн засгийн багш, Y их сургуулийн докторант) нэр нь орсон Австралийн их сургууль тус бүр судалгааны бүтээлийг бүрэн эзэмшиж хүсэлт гаргах боломжтой. Туслах ажилтан, хүндэт ажилтан, чөлөө авсан ажилчдыг их сургууль нь тодорхойлсон бол их сургуулийн харьяанд тооцно.

2.5. Чанарын хэмжүүрүүд

Ном болон номын бүлгийн чанарын хэмжүүр бол хэвлэлийн газар буюу байгууллага нь ERM-ын шаардлагыг хангасан байх ёстой. Харин хурлын өгүүлэл, сэтгүүлийн

өгүүлэлүүдийн хувьд чанарын хэмжүүр нь тухайн судалгааны ажлыг хэвлэхээс өмнө хянан магадлагаа хийдэг байх ёстой.

2.6. Арилжааны зориулалттай хэвлэлийн газар

Арилжааны зориулалттай хэвлэлийн газар нь үндсэн үйл ажиллагаа нь борлуулах зорилгоор ном хэвлэх, түгээх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Хэвлэх үйл ажиллагаа нь тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаа биш хэдий ч арилжааны хэвлэлд зориулагдсан тусдаа зохион байгуулагдсан нэгж бүхий үндсэн байгууллага эсвэл гуравдагч этгээдээс дэмжлэг авдаггүй бол байгууллагыг арилжааны зориулалттай хэвлэлийн газар гэж үзнэ.

2.7. Хянан магадлагаа

ERM-н хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний журам бол судалгааны бүтээлийг хэвлэхийн өмнө судалгааны баримт бичгийг бүхэлд нь хараат бус, мэргэшсэн шинжээчдээр үнэлүүлж, хянаж үзэхийг шаарддаг журам юм. Энд хараат бус гэдэг нь зохиогчоос хараат бус гэсэн үг юм.

Сэтгүүлийн өгүүллийн хувьд дараах зүйлсийн аль нэгийг нотлох баримт болгон хүлээн зөвшөөрнө:

- Сэтгүүл нь ERM 2018 сэтгүүлийн жагсаалтад орсон байх
- Сэтгүүл Томсон Ройтерс -ийн мастер сэтгүүлийн жагсаалтад байх (<http://ip-science.thomsonreuters.com/cgi-bin/jrnlst/jlsearch.cgi?PC=MASTER>),
- Сэтгүүл Ульричийн баазд (Ulrich's Knowledgebase) хянан магадлагаа хийгдсэн байдлаар ангилагдсан байх. (www.ulrichsweb.com)
- Сэтгүүл дээр зохиогчдын оролцоо хянан магадлагаа хийгдсэнийг илтгэх нотолгоотой байх
- Сэтгүүлийн редакторын мэдэгдэл эсвэл баталгаа нь зохиогчдын оролцоо хянан магадлагаа хийгддэгийг илтгэдэг.
- Тухайн судалгааны бүтээлтэй холбоотой шүүмжлэгчийн үнэлгээний хуулбар

2.8. Цахим бүтээлүүд

Цахим судалгааны бүтээлийг хүсэлт гаргаж буй судалгааны бүтээлийн бүх шалгуурыг хангасан тохиолдолд тооцох боломжтой.

Англиас өөр хэлээр хэвлэгдсэн судалгааны бүтээлүүд

Хүсэлт гаргасан судалгааны бүтээл бүр нь нотлох баримтаар нотлогдсон байх ёстой тул судалгааны бүтээлээс хангалттай мэдээллийг хуулж, MRIS-ийн бүртгэлд цахим хэлбэрээр хавсаргах нь чухал. Ингэснээр тэдгээрийг шалгаж баталгаажуулах боломжтой юм.

MRIS-ийн бүх ангилал (категориуд), тэр ч байтугай ERM-д тооцогдох боломжгүй бүтээлүүдийг ч нотлох баримтыг англи хэл рүү орчуулахыг шаарддаг. Энэ нь үнэн зөв мэдээллийг оруулж, шалгаж баталгаажуулах зорилготой юм.

Анхаарах зүйл: Хэрэв англи орчуулга байхгүй бол ERM-ны шаардлага хангахгүй бөгөөд шалгалт, баталгаажуулалт хийгдэхгүй.

Та дараах нотлох баримтыг англи хэлээр өгөх ёстой.

- Гарчиг, зохиогч, ISBN/ISSN, DOI, хэвлэлийн компани, хэвлэгдсэн газар, сэтгүүлийн дугаар, зохиогчийн эрхэд хамаарах огноо зэргийг харуулсан хуудсууд
- Зохиогчийн ШУТИС-тай холбоотойг нотлох харьяа байгууллагын хуудас
- Агуулгын хүснэгт ба оролцогчдын нэрсийн жагсаалт
- Оршил/Өмнөх үг/Оршил (номонд шаардлагатай)
- Хүсэлт гаргасан бүтээлийн хураангуй эсвэл танилцуулга

Нотлох баримтыг PDF хэлбэрээр хадгалж, MRIS-н судалгааны бүтээлийн бүртгэлд байршуулна .

НОМ

А Ном

- ERM-ын шалгуурыг хангасан номыг A1 гэж ангилалд орно.
- Хэрэв ном нь ERM-ны шаардлагыг хангахгүй бол A2 - A5 ангилалын аль нэгээр нь MRIS-д оруулна.
- Хэрэв бүтээлийн тухай мэдээлэл ШУТИС-д хийгдээгүй бол бүтээлийг гадаад 'A' ангилал (ExtA1 - ExtA4)-д орно.

Шаардлагатай нотлох баримт:

Номны хувьд

- Хэвлэгдсэн он
- Зохиогчийн харьяалал
- Бүтээл/Номын гарчиг
- Нийт хуудасны тоо
- Цувралын гарчиг (зөвхөн цувралын нэг хэсэг бол)
- DOI (хэрэв байгаа бол)
- Хянан магадлагааны мэдээлэл
- Номын дэлгэрэнгүй мэдээлэл (ISBN, хэвлэлийн компани, хэддэх хэвлэх болох, боть г.м)
- Баримт бичиг: Хэвлэгдсэн номын PDF - бүх хуудас (нүүрнээс арын хавтас хүртэл)

A1

Номонд тавих ERM-ын шаардлагууд

- Зохиогч/зохиогчидтой байх
- Эрдэм шинжилгээний үр дүнтэй ажил байх ёстой
- ISBN-тэй байх
- Бизнесийн хараат бус хэвлэлийн байгууллагын тухай ERM-ын тодорхойлолтыг хангасан байгууллагаар хэвлүүлсэн байх
- Хэвлэмэл, CD-ROM, цахим ном зэргийг захиалгаар болон төлбөртэйгээр худалдаанд гаргах боломжтой байх
- Зорилтот хэрэглэгчид нь эрдэмтэн судлаачид байх

Энэ шалгуурт тохирох номуудад дараахь зүйлс орно.

- Эрдэм шинжилгээний чухал бичвэрүүд (тухайлбал хөгжим, дундад зууны эсвэл сонгодог зохиолууд)
- Түүхэн үйл явдлын шинэ тайлбарууд
- Өмнө нь олж илрүүлсэн судалгааны үр дүнд тулгуурласан шинэ санаа эсвэл ойлголт

	Энэ шалгуурыг хангах боломжгүй номууд: • сурах бичиг (A2 ангилалд багтах боломжтой) • антологи (A2 эсвэл A4 ангилалд багтах боломжтой) • Дахин засварласан ном (A4 ангилал) • Зохиол гэх мэт бүтээлч ажлууд (J ангилал) • Орчуулга (P ангилал) • Засварласан болон шинээр хэвлэсэн хувилбар (A3 ангилал) • Лавлах ажил - гарын авлага, зааварчилгаа (засварласан бол D ангилал эсвэл A4 ангилалд багтах)
A2	ERM-д орохгүй ном • Зохиогч/зохиогчидтой байх • Эрдэм мэдлэгийн ач холбогдолтой ажил байх • ERM-ын хэвлэлийн компаний тухай тодорхойлолтыг хангаагүй хэвлэлийн байгууллагаар хэвлүүлсэн. Үүнд их сургуулийн тэнхим, НҮБ, ЮНЕСКО, ЭЗХАХБ, ДЭМБ зэрэг судалгааны байгууллагууд болон хувийн хөрөнгө оруулалттай компаниуд байж болно. Эсвэл чиглэл нь сурах бичиг гэх мэт ERM- д тодорхойлсон эрдэм шинжилгээний судалгааны шалгуурт нийцэхгүй байх Шалгуурыг хангах номнууд • их сургуулийн тэнхимээс хэвлүүлсэн судалгааны нэг сэдэвт бүтээл • Их сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг • их сургуулийн тэнхимүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай компаниуд, зохиогчийн мөнгөөр ном хэвлэдэг хэвлэлийн газар • Хураангуйлсан антологи • Үзэсгэлэнгийн каталог Шалгуурыг хангахгүй номууд: • Бүтээлч ажил, жишээ нь. романууд - зохиогчийн төсөөллөөс хамаарна (J ангилал) • Засгийн газрын үнэлгээ/судалгааны газар, албадын хэвлэлүүд (K ангилал) • Их сургуулийн ажлын баримт, техникийн тайлан, хэлэлцүүлгийн материал гэх мэт (K ангилал) • Дунд, бага, сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зориулсан сурах бичиг (A5 ангилал) • Эрдэм шинжилгээний тайлбаргүй орчуулга эсвэл номын гүйцэд биш богино, хэсэгчилсэн орчуулга (P2 ангилал) • • Хэрэв орчуулга нь эрдэм шинжилгээний чухал ажил бөгөөд орчуулагч үүнийг дагалдан шинжлэх ухааны шүүмжлэлийн бичвэрийг бий болгосон бол. • • Орчуулагч, зохиогч нэгтэй номын орчуулга эсвэл орчуулагч нь орчуулгатай холбоотой эрдэм шинжилгээний томоохон бүтээл бичиж тэр нь эрдэм шинжилгээний чухал ажил байх (A1 ангилал эсвэл P1 ангилал байж болно) • 1-р хэвлэл биш орчуулсан номууд (P5 ангилал)
A3	Засварласан болон шинэчлэн хэвлэсэн ном

	• Өмнө нь хэвлэгдсэн ном • Одоогийн зохиогч эсвэл редактор, эсвэл өмнөх зохиогч • редакторын нэмэлт материал ихтэй эсвэл материалыг өөрчилснөөр шинэчлэгдсэн өмнө нь хэвлэгдсэн судалгааны өгүүллийн цуглуулга Шалгуурыг хангахгүй номууд: • Их хэмжээний нэмэлт, засвар оруулаагүй дахин хэвлэгдсэн ном (A5 ангилал) • Хэвлэгдсэн бүтээлийн засварласан, шинэ хэвлэлт (J ангилал)
A4	Засварласан ном Энэ ангилал нь хэд хэдэн зохиогчтой номын редакторт зориулагдсан бөгөөд 1-р хэвлэл бол номын хавтаснаас эхлээд арын хавтас хүртэл бүхэлд нь PDF хэлбэрээр, бусад бүх хэвлэлд MRIS-д байршуулахын тулд зөвхөн эхний хэсгийг л оруулах шаардлагатай. Шалгуур хангах номнууд: • Лавлах ном • Нэг сэдэвт бүтээл (монограф) эсвэл • Олон зохиогчдын бичсэн богино хэмжээний цуврал боть. Шалгуур хангахгүй номнууд: • засварласан хэвлэгдсэн бүтээлүүд (J ангилал) Нэмэлт нотолгоо шаардлагатай (Зөвхөн редактор номын тусдаа бүлгүүдийг шаардаж байвал): • Баримт бичиг: Номыг бүхэлд нь биш зөвхөн нүүр хуудасны PDF файлыг шаардана (номын хавтас, зохиогчийн эрхийн дэлгэрэнгүй мэдээлэл, хэвлэсэн газрын дэлгэрэнгүй мэдээлэл, агуулга, ном бичихэд оролцсон зохиогчдын нэрсийн жагсаалт, редакторын мэдээлэл, оршил/удиртгал/өмнөх үг эсвэл эдгээр нь байхгүй бол 1-р бүлэг)
A5	Шалгуур хангаагүй ном Номын бусад ангиллын шалгуурыг хангаагүй хэвлэгдсэн ном • Оршил/дүгнэлт/удиртгал/өмнөх үг
A99	Scopus болон бусад мэдээллийн сангаас импортолсон ном RSD-ийн ажилтнууд MRIS руу гадны мэдээллийн сангаас хэвлэсэн бүтээлүүдийг оруулдаг. Ингэхдээ бүртгэлийг бөглөх шаардлагатай. Бүртгэл шинэчлэгдсэний дараа A99 ангиллыг өөр A ангиллаар солино.
Ext A1	ШУТИС-д хийгдээгүй, ERM-ийн шаардлага хангасан ном • Зохиогчийн хийсэн судалгаа өөр газар хийгдэснээс биш ERM-д тавигдах шаардлагыг хангасан.
Ext A2	ШУТИС-д хийгдээгүй, ERM-ийн шаардлага хангахгүй ном ERM-ийн шаардлага хангахгүй, зохиогчийн судалгааг өөр газар хийсэн. A3 ба A5 ангилал гадны ажил бол ExtA2 гэж ангилна уу.
Ext A4	ШУТИС-д хийгдээгүй засварласан ном • Зохиогч нь ШУТИС-аас өөр газарт байхдаа засвар хийсэн ном

НОМЫН БҮЛЭГ

В	Номын бүлэг - ERM-ийн шалгуурыг хангасан номын бүлгийг В1 гэж ангилах ёстой. - Номын бүлэг нь ERM-ийн шаардлагад нийцэхгүй бол MRIS-д хэвлэгдсэн нийтлэлийг бусад 'В' ангиллын аль нэгээр (В2 - В5) оруулна уу. Хэрэв судалгааг ШУТИС-д хийгээгүй бол уг номын бүлгийг гадны 'В' ангилалд оруулна уу (ExtB1 - ExtB3). Шаардлагатай нотолгоо: • Хэвлэгдсэн он • Бүлгийн нэр • Зохиогчийн харьяа байгууллага • Номын гарчиг • Хуудсын тоо • DOI • Хөндлөнгийн шүүмж • Номын дэлгэрэнгүй мэдээлэл (ISBN, хэвлэлийн компани, хэддэх хэвлэх болох, боть г.м) • Баримт бичиг: Номын нүүр хуудас болон бүлгийн PDF (номын хавтас, зохиогчийн эрхийн дэлгэрэнгүй мэдээлэл, хэвлэсэн газрын дэлгэрэнгүй мэдээлэл, агуулга, ном бичихэд оролцсон зохиогчдын нэрсийн жагсаалт, редакторын мэдээлэл, оршил/удиртгал/өмнөх үг эсвэл эдгээр нь байхгүй бол 1-р бүлэг гэх мэт)
В1	ERM-ийн шаардлагыг хангах номын бүлэг • Зохиогч/зохиогчидтой байх • Эрдэм шинжилгээний үр дүнтэй ажил байх • ISBN-тэй байх • Бизнесийн хараат бус хэвлэлийн байгууллагын тухай ERM-ын тодорхойлолтыг хангасан байгууллагаар хэвлүүлсэн байх • Хэвлэмэл, CD-ROM, цахим ном зэргийг захиалгаар болон төлбөртэйгээр худалдаанд гаргах боломжтой байх • Зорилтот хэрэглэгчид нь эрдэмтэн судлаачид байх Шалгуур хангах номын бүлгүүд: • судалгааг тайлагнаж, судалгааны талбарт томоохон хувь нэмэр оруулж буй оршил бүлэг бүхий засварласан цуглуулга. • Номын бүлгийн хэмжээний эрдэм шинжилгээний чухал бичвэр • Одоогийн судалгааны чухал тойм

	• Эрдэм шинжилгээний чухал бичвэрүүд (тухайлбал хөгжим, дундад зууны эсвэл сонгодог зохиолууд) • Түүхэн үйл явдлын шинэ тайлбарууд • Өмнө нь олж илрүүлсэн судалгааны үр дүнд тулгуурласан шинэ санаа эсвэл ойлголт Энэ шалгуурыг хангахгүй номын бүлгүүд: • антологи дахь сурах бичиг болон тэмдэглэл (B2 ангилал) • Дахин засварласан ном (A4 ангилал) • Зохиол гэх мэт бүтээлч ажлууд (J ангилал) • Орчуулга (P ангилал) • Засварласан болон шинээр хэвлэсэн хувилбар (A3 ангилал) Лавлах ажил - гарын авлага, зааварчилгаа (засварласан бол D ангилал эсвэл A4 ангилалд багтах)
B2	Номын бүлэгт тавих ERM-н биш шаардлагууд • Зохиогч/зохиогчидтой байх • Эрдэм мэдлэгийн ач холбогдолтой ажил байх • ERM-ын хэвлэлийн компаний тухай тодорхойлолтыг хангаагүй хэвлэлийн байгууллагаар хэвлүүлсэн. Үүнд их сургуулийн тэнхим, НҮБ, ЮНЕСКО, ЭЗХАХБ, ДЭМБ зэрэг судалгааны байгууллагууд болон хувийн хөрөнгө оруулалттай компаниуд байж болно. Эсвэл чиглэл нь сурах бичиг гэх мэт ERM- д тодорхойлсон эрдэм шинжилгээний судалгааны шалгуурт нийцэхгүй байх Шалгуурыг хангах номын бүлгүүд • Их сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг • их сургуулийн тэнхимүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай компаниуд, зохиогчийн мөнгөөр ном хэвлэдэг хэвлэлийн газар • Хураангуйлсан антологи • Үзэсгэлэнгийн каталог Шалгуурыг хангахгүй номууд: • Бүтээлч ажил, жишээ нь. Романууд - зохиогчийн төсөөллөөс хамаарна (J ангилал) • Засгийн газрын үнэлгээ/судалгааны газар, албадын хэвлэлүүд (K ангилал) • Их сургуулийн ажлын баримт, техникийн тайлан, хэлэлцүүлгийн материал гэх мэт (K ангилал) • Дунд, бага, сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зориулсан сурах бичиг (A5 ангилал) • Эрдэм шинжилгээний тайлбаргүй орчуулга эсвэл номын гүйцэд биш богино, хэсэгчилсэн орчуулга (P2 ангилал) • Хэрэв орчуулга нь эрдэм шинжилгээний чухал ажил бөгөөд орчуулагч үүнийг дагалдан шинжлэх ухааны шүүмжлэлийн бичвэрийг бий болгосон бол. • Орчуулагч, зохиогч нэгтэй номын орчуулга эсвэл орчуулагч нь орчуулгатай холбоотой эрдэм шинжилгээний томоохон бүтээл бичиж тэр нь эрдэм шинжилгээний чухал ажил байх (A1 ангилал эсвэл P1 ангилал байж болно) • 1-р хэвлэл биш орчуулсан номууд (P5 ангилал)
B3	Засварласан номын бүлэг Номын бүлгийн хангах шалгуур: • Засвар хийгдсэн байх

B5	Бусад шалгуурт тохирохгүй номын бүлэг Бусад В ангиллын шалгуурыг хэвлэгдсэн бүлэг хангаагүй Товч оршил/дүгнэлт/өмнөх үг/Хавсралт/редактор
B99	Scopus болон бусад мэдээллийн сангаас импортолсон номын бүлэг RSD-ийн ажилтнууд MRIS руу гадны мэдээллийн сангаас бүтээлүүдийг оруулдаг. Ингэхдээ бүртгэлийг бөглөх шаардлагатай. Бүртгэл шинэчлэгдсэний дараа B99 ангиллыг өөр В ангиллаар солино.
Ext B1	ШУТИС-д хийгдээгүй ERM-ийн шаардлага хангасан номын бүлэг Зохиогчийн хийсэн судалгаа өөр газар хийгдэснээс биш ERM-д тавигдах шаардлагыг хангасан.
Ext B2	ШУТИС-д хийгдээгүй ERM-ийн шаардлага хангахгүй номын бүлэг ERM-ийн шаардлага хангахгүй, судалгааг ШУТИС-с өөр газар хийгдсэн байна. B5 ангилал гадны ажлыг ExtA2 гэж ангилна уу.
Ext B3	ШУТИС-д хийгдээгүй засварласан номын бүлэг Зохиогч нь ШУТИС-аас өөр газарт байхдаа засвар хийсэн номын бүлэг

СЭТГҮҮЛИЙН СУДАЛГААНЫ ӨГҮҮЛЭЛ

С	Сэтгүүлийн судалгааны өгүүлэл - ERM-ын шалгуурыг хангасан судалгааны өгүүллийг C1 гэж ангилалд оруулна. - Хэрэв судалгааны өгүүлэл нь ERM-ны шаардлагыг хангахгүй бол C-ийн аль нэг ангилалиар (C2 - C5) MRIS-д оруулна. Хэрэв бүтээлийн тухай мэдээлэл ШУТИС-д хийгдээгүй бол бүтээлийг гадаад 'C' ангилал (ExtC1 - ExtC4)-д орно. Шаардлагатай нотлох баримт: - Хэвлэгдсэн он - Өгүүллийн гарчиг - Зохиогчийн харьяалал - Сэтгүүлийн гарчиг - Боть - Хэвлэлт - Хуудасны тоо - DOI - Сэтгүүлийн дэлгэрэнгүй мэдээлэл (ISSN, Шүүмжийн хуудас, хэвлэлийн компани гэх мэт) - Баримт бичиг: Өгүүллийн PDF
C1	ERM-ийн шаардлагыг хангах судалгааны өгүүлэл - Зохиогч/зохиогчидтой байх - Эрдэм шинжилгээний үр дүнтэй ажил байх - ISSN-тэй хянан магадлагаа хийгддэг эрдэм шинжилгээний сэтгүүл байх Шалгуурыг хангах судалгааны өгүүлэл:

	• Анхдагч судалгаа байх • Судалгааны тэмдэглэл • Судалгааны Шалгуурыг хангахгүй судалгааны өгүүлэл: • Редакторт илгээсэн захиа (C5 ангилал) • Судалгаа (C5 ангилал) • Тодорхой мэргэжлийн салбарын мэдлэгийг мэргэжилтнүүдэд мэдээлэх зорилготой судалгааны өгүүлэл (C5 ангилал) • Сонин, сэтгүүлийн нийтлэлүүд (N ангилал) • Редакци, номын тойм (C5 ангилал) • Анхдагч судалгааны товч тайлбар, харилцаа (C5 ангилал) • Урлагийн үзэсгэлэн, концерт, театрын бүтээлүүдийн тойм (C5 ангилал)
C2	Эрдэм шинжилгээний сэтгүүлийн шүүмж хийгдээгүй судалгааны өгүүлэл • Эсвэл редакцийн зөвлөлийн хяналтанд байдаг мэргэжлийн сэтгүүл эсвэл эрдэм шинжилгээний сэтгүүлд шүүмж хийгдээгүй ажил Шалгуурыг хангах сэтгүүлийн өгүүллүүд: • Тодорхой нэг салбарт дадлагажигч нарт мэдлэгийн төлөв байдлын хураангуй буюу зааварчилгааны цуглуулга бүхий судалгааны өгүүлэл • Эрүүл мэндийн жишиг судалгаа Шалгуурыг хангахгүй судалгааны өгүүлэл: • Редакцийн нийтлэл (C5 ангилал) • Редакторт илгээсэн захиа (C5 ангилал) • Судалгаа (C5 ангилал) • Тодорхой мэргэжлийн салбарын мэдлэгийг мэргэжилтнүүдэд мэдээлэх зорилготой судалгааны өгүүлэл (C5 ангилал) • Сонин, сэтгүүлийн нийтлэлүүд (N ангилал) • Редакци, номын тойм (C5 ангилал) • Анхдагч судалгааны товч тайлбар, харилцаа (C5 ангилал) Урлагийн үзэсгэлэн, концерт, театрын бүтээлүүдийн тойм (C5 ангилал)
C3	Эрдэм шинжилгээний сэтгүүл дэх захиа, тэмдэглэл гэх мэт •
C4	Эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакц • Сургалтын байгууллагын редакцийн хариуцлага хүлээхээр тодорхойлогдсон нэг буюу хэд хэдэн гишүүдээр редакц хийлгэгддэг.
C5	Шүүмж хийгддэггүй сэтгүүл

	Бусад С ангиллын шалгуурыг хангаагүй сэтгүүл
C99	Scopus болон бусад мэдээллийн сангаас импортолсон эрдэм шинжилгээний өгүүлэл RSD-ийн ажилтнууд MRIS руу гадны мэдээллийн сангаас бүтээлүүдийг оруулдаг. Ингэхдээ бүртгэлийг бөглөх шаардлагатай. Бүртгэл шинэчлэгдсэний дараа B99 ангиллыг өөр В ангиллаар солино.
ExtC1	ШУТИС-д хийгдээгүй ERM-ийн шаардлага хангасан эрдэм шинжилгээний өгүүлэл Зохиогчийн хийсэн судалгаа өөр газар хийгдэснээс биш ERM-д тавигдах шаардлагыг хангасан.
ExtC2	ШУТИС-д хийгдээгүй ERM-ийн шаардлага хангахгүй эрдэм шинжилгээний өгүүлэл ERM-ийн шаардлага хангахгүй, судалгааг ШУТИС-с өөр газар хийгдсэн байна. B5 ангилал гадны ажлыг ExtA2 гэж ангилна уу.
ExtC4	ШУТИС-д хийгдээгүй засварласан эрдэм шинжилгээний өгүүлэл Зохиогч нь ШУТИС-аас өөр газарт байхдаа засвар хийсэн номын бүлэг

Ашигласан судалгааны ажил (Ном зүй)

D Ашигласан судалгааны ажил (ном зүй) - ERM-ийн бүх шалгуурыг хангасан бүтээлүүдийг A1 эсвэл B1 гэж ангилах ёстой. - Өөрийн гэсэн DOI болон хуудасны дугаартай онлайн бичлэгүүд нь хэвлэх хувилбар байхгүй тохиолдолд нэвтэрхий толь бичгийн нүүрийг оруулах шаардлагагүй. Шаардлагатай нотлох баримт: - Хэвлэгдсэн он - Гарчиг - Зохиогчийн харьяалал - DOI - Хуудасны дугаар - Иш татсан судалгааны ажлын гарчиг - Номын дэлгэрэнгүй мэдээлэл (ISBN, хэвлэлийн компани, хэвлэлтийн дугаар, боть гэх мэт) - Баримт бичиг: Бичиг баримтын PDF файл болон хэвлэгдсэн судалгааны бүтээлийн нүүр хуудас	
D1	Нэр хүнд бүхий ашигласан судалгааны ажлыг (ном зүйг) оруулах Толь бичиг, нэвтэрхий толь, заавар, гарын авлага зэрэг эрдэм шинжилгээний хэвлэлд оруулсан томоохон судалгааны ажлыг мэдүүлэхэд ашигладаг ангилал юм. Хэвлэлийн компани нь бусад арилжааны хэвлэлийн байгууллагын тодорхойлсон ERM-ийн шалгуурт нийцсэн байх шаардлагагүй.

	Ашигласан материал (ном зүй) нь дараах шалгуурт нийцсэн байна. Үүнд: • Тухайн зохиогч ашигласан судалгааны ажилдаа (ном зүй) оруулсан хувь нэмэртэй байх • Ижил зохиогч/зохиогчдын ашигласан судалгааны ажлын ялгаатай хэсгүүдэд оруулсан хувь нэмрээр нь дараалуулсан байх • Өмнөх хэвлэгдсэн иш татан ашигласан ажлууд ихээхэн засвар/нэмэлт оруулсан байх • ном зүй, тайлбартай ном зүйтэй байх Шалгуурыг хангахгүй ашигласан материал (ном зүй): • Зөвхөн зохиогчийн бичсэн ном зүй (A2 ангилал) • Редактор/редакторуудын ашигласан ажил (A4 ангилал) • Өмнө хэвлэгдсэн иш татсан ажлын бага зэргийн/нэмэлт засвар
D2	Бага зэрэг ашигласан судалгааны ажлыг оруулах нэвтэрхий толь, толь бичиг, заавар, гарын авлага зэрэгт хийх бага зэргийн тойм
Ext D1	ШУТИС-д хийгдээгүй үндсэн ажлыг оруулах Зохиогч нь ШУТИС-аас өөр газарт байхдаа хийсэн судалгаа
Ext D2	ШУТИС-д хийгдээгүй ном зүйг оруулах Зохиогч нь ШУТИС-аас өөр газарт байхдаа хийсэн судалгаа

Хурлын өгүүлэл

Е Хурлын өгүүлэл

- ERM -ын шалгуурыг хангасан хурлын өгүүлэлийг E1 гэж ангилна.
- Хэрэв хурлын өгүүлэл ERM -ын шаардлагад нийцэхгүй бол та MRIS-д бусад 'Е' ангиллын аль нэгээр (E2 - E5) оруулах ёстой. Хэрэв ШУТИС-д хийгдээгүй суурь судалгаа бол тухайн өгүүлэлийг external 'Е' ангилалд оруулна (ExtE1 - ExtE4).

Шаардлагатай нотлох баримт:

- Хэвлэгдсэн он
- Хурлын өгүүллийн гарчиг
- Зохиогчийн харьяалал
- Хурлын нэр
- Хуудасны дугаар
- Хянан магадлагаа
- DOI

- Хурлын дэлгэрэнгүй мэдээлэл (ISBN, редактор, хэвлэлтийн дугаар, хэвлэлийн компани, хурлын огноо гэх мэт) - Баримт бичиг: Хурлын өгүүллийн PDF файл	
E1	ERM-ын шаардлагад нийцсэн хурлын өгүүлэл • Зохиогч/зохиогчидтой байх • Эрдэм шинжилгээний үр дүнтэй ажил байх • Илтгэл бүхэлдээ шүүж хийгдсэн нийтлэгдсэн байна • Үндэсний болон олон улсын ач холбогдолтой хурал байх Шалгуурыг хангахгүй хурлын өгүүлэл: • Хураангуй (E3 ангилал) • тараах материал (E5 ангилал) • постер илтгэл (E3 ангилал)
E2	Хурлын илтгэлүүдийн бичмэл хувилбар • Хурлын илтгэлийн бичмэл хувилбар • Шүүлт/хянан магадлагаа хийгдээгүй өгүүлэл болон • Дараа нь хэвлэгдсэн Шалгуурыг хангах боломжгүй хурлын илтгэлүүд: • Үндэсний хэмжээний ач холбогдол багатай семинар, хуралд тавьсан хурлын өгүүлэл (E5 ангилал) • Хуралд илтгэл тавьсан боловч дараа нь хэвлэгдээгүй илтгэлүүд (E5 ангилал) • Хураангуй (E3 ангилал)
E3	Хураангуй • Хурлын илтгэлүүдийн дараа нь хэвлэгдэхгүй түүвэр Энэ шалгуурыг хангасан хурлын илтгэлүүд

	• Постер илтгэл • Хураангуй
E4	Засвар хийсэн хурлын эмхэтгэлүүд • Сургалтын байгууллагын редакцийн хариуцлага хүлээхээр тодорхойлогдсон нэг буюу хэд хэдэн гишүүдээр хурлын эмхэтгэл редакц хийгддэг. Энэ шалгуурыг хангах боломжгүй хурлууд: • Их сургуулийн ажилтан редакцийн зөвлөх зөвлөлд багтдаггүй ботийн жагсаалтад орсон редакторуудын жагсаалтанд байхгүй засвар хийсэн боть
E5	Бусад шалгуурыг хангаагүй хурлын өгүүлэл Хурлын нийтлэл нь бусад E ангиллын шалгуурыг хангадахгүй
E99	Scopus болон бусад мэдээллийн сангаас импортолсон хурлын өгүүлэл RSD-ийн ажилтнууд MRIS руу гадны мэдээллийн сангаас бүтээлүүдийг оруулдаг. Ингэхдээ бүртгэлийг бөглөх шаардлагатай. Бүртгэл шинэчлэгдсэний дараа E99 ангиллыг өөр E ангиллаар солино.
ExtE1	ШУТИС-д хийгдээгүй ERM-ийн шаардлага хурлын өгүүлэл Зохиогчийн хийсэн судалгаа өөр газар хийгдэснээс биш ERM-д тавигдах шаардлагыг хангасан.
ExtE2	ШУТИС-д хийгдээгүй ERM-ийн шаардлага хангахгүй хурлын өгүүлэл ERM-ийн шаардлага хангахгүй, судалгааг ШУТИС-с өөр газар хийгдсэн байна. E3 болон E5 ангилал гадны ажлыг ExtE2 гэж ангилна уу.
ExtE4	АНУ-д хийгдээгүй засвар хийсэн хурлын эмхэтгэл Зохиогч нь ШУТИС-аас өөр газарт байхдаа засвар хийсэн хурал

БУСАД АНГИЛАЛ

G Компьютерын програм хангамж Шаардлагатай нотлох баримт: - Хэвлэгдсэн он - Програмын нэр - Зохиогчийн харьяалал - Каталогийн дугаар (хэрэв байгаа бол) - Хувилбар (хэрэв байгаа бол) - Түгээх - Борлуулагч - Баримт бичиг: Дистрибьютерийн хуудсан дээрх програм хангамжийн URL/DOI болон програм хангамж/програмын гарын авлагын PDF файл	
G1	Компьютерын программ, шинэлэг, арилжааны • Арилжааны чанартай шинэлэг програм хангамжын бүтээгдэхүүн

	- Хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэгч эсвэл дистрибьютерээр дамжуулан борлуулах эсвэл хуваан ашиглах хэлбэрээр түгээх Үүнд хамаарах: - Системийн программ хангамж (үйлдлийн систем, хөрвүүлэгч, компьютерийн нөөцийг удирдах хэрэгсэл гэх мэт маш энгийн түвшний программууд) - хэрэглээний программ хангамж (үг боловсруулах, хүснэгт үүсгэх, график үүсгэх, цахим шуудан дамжуулах гэх мэт тодорхой үүрэг, функцийг гүйцэтгэдэг програм хангамж) - Эрдэмтдэд зориулсан шинэлэг програм хангамжийн бүтээгдэхүүн - Компьютерийн програм хангамжийн эхний хувилбараас бусад хувилбаруудыг зөвхөн мэдэгдэхүйц сайжруулсан тохиолдолд Үл хамаарах: - Хүний чадвараар хязгаарлагдах мультимедиа бүтээгдэхүүн (F ангиллыг үзнэ үү) - Бүтээлч мультимедиа үйлдвэрлэл (J ангиллыг үзнэ үү)
G2	Худалдааны биш компьютерын програм (Нээлттэй програмуудыг оруулаад) - их дээд сургуулийн бакалаврын болон магистрын дараах оюутнуудад зориулагдсан шинэлэг програм хангамжийн бүтээгдэхүүн - ерөнхий боловсролын дунд, бага, сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зориулагдсан программ хангамж
ExtG1	ШУТИС-д хөгжүүлээгүй программ хангамж Зохиогчийг ШУТИС-д байхдаа хийгээгүй ажил. Тэмдэглэл таб-д: ШУТИС -иас өмнө (Зохиогчийн нэр), (Байгууллагын нэр) дээр хийсэн судалгаа.

I Шинэ бүтээл (нээлт)

Ерөнхий шалгуур:

- Энэ ангилалд Австрали эсвэл өөр улсад анх удаа олгосон тодорхой бүтээгдэхүүн, технологийн үйл ажиллагааны бүрэн патент (эсвэл түүнтэй адилтгах) хамаарна.
- Шинэ бүтээлийг мэдүүлэгч нь патент авах судалгааг ШУТИС-ийн ажилтан эсвэл оюутан байсан байх ёстой

Шаардлагатай нотлох баримт:

- Хэвлэгдсэн он
- Зохиогчийн харьяалал
- Баримт бичиг: Патентийн PDF файл
- ШУТИС-д хийгээгүй зохиогчийн судалгаанд ангилал байхгүй-

I2

Зөвшөөрөл нь олгогдсон патент

Энэ ангилд дараахь патентууд орно:

- Бүтээгдэхүүн, технологийн үйл ажиллагаанд олгогдсон бүрэн хэмжээний патент (эсвэл түүнтэй адилтгах)
- Анх хүсэлт гаргасан жилдээ олгогдсон байх
- Их сургууль, бизнесийн охин компани, аж ахуйн нэгж, харьяа судалгааны байгууллагын өмчлөл буюу патент авах судалгаа нь ШУТИС-д хийсэн байх ёстой.
- Ижил бүтээгдэхүүн, технологийн үйл ажиллагаанд олон тооны эрх аваагүй байх
- патентын эрхийн шийдвэр гараагүй байгаа өргөдлийг оруулахгүй байх

Нэмэлт шаардлагатай нотлох баримт:

- Патент олгосон он
- Нээлт, шинэ бүтээлийн нэр
- Патентийн дугаар
- Бүртгүүлсэн улс
- Патентийн төрөл
- Бүртгэлсэн эзэмшигч

I5

Богино хугацааны (Түр) патент

Шинэ бүтээлийн түр патент авах өргөдөл.

Үүнд:

- Патентийн өргөдөл

	Нэмэлт шаардлагатай баримт: - Патентийн нэр - Бүртгүүлсэн огноо - хэвлэмэл хувь/өргөдлийн дугаар - Улсын өргөдлийн мэдүүлэг
16	Ургамал үржүүлэгчийн эрх Ургамал үржүүлэгчийн эрх (УҮЭ-PBRs) нь шинэ сортын ургамал, мөөгөнцөр үржүүлэгчдийн эзэмшдэг өмчийн эрх юм. Эдгээр эрх нь хууль ёсны дагуу хэрэгжих боломжтой бөгөөд PBR-ийн хугацаанд шинэ сорт эсвэл түүний үржүүлгийн материалыг зах зээлд гаргах арилжааны онцгой эрхийг олгодог. Шинэ сортын ургамлыг үзүүлэх тохиолдолд PBRs олгодог. ☐ бусад олон төрлийн нийтлэг мэдээлэлээс ялгаатай онцгой байх ☐ нэг төрлийн байх ☐ зөвшөөрөгдсөн хугацаанаас өмнө гадуур худалдахгүй байх ☐ зохимжтой нэртэй байх. Шаардлагатай нэмэлт нотлох баримт: - Ургамал үржүүлэгчийн эрхийн төрөл - Ургамал үржүүлэгчийн эрхийн нэр - Ургамал үржүүлэгчийн эрхийн дугаар - Хүчин төгөлдөр болсон он - Бүртгэлсэн эзэмшигч
17	Бүртгэлтэй загвар Шинэ болон өвөрмөц загварт олгосон зохиогчийн эрх. Бүртгэгдсэн загварыг шалгаж баталгаажуулсны дараа өмчлөгч нь бүртгүүлсэн загварыг ашиглах, тусгай зөвшөөрөл олгох ба/эсвэл худалдах, түүнийг зөрчигчийн эсрэг хэрэгжүүлэх онцгой эрхтэй. Энэ утгаараа дизайн гэдэг нь тухайн бүтээгдэхүүнд хэрэглэхэд түүнийг гадаад үзэмжээр нь өвөрмөц болгодог онцлог шинж чанаруудыг хэлдэг. Үүнд хэлбэр, хэв маяг, гоёл чимэглэл багтаж болно Сонгон шалгаруулалтад тэнцэхийн тулд бүртгүүлсэн загваруудыг холбогдох шаардлагын дагуу тодорхой хугацаанд эрх бүхий судлаач, байгууллага, байгууллагын охин компани болон/эсвэл тухайн байгууллагатай холбоотой компанид олгосон байх ёстой. Бүртгэгдсэн загварын судалгаа нь судалгааны тодорхойлолтод нийцэж байх тохиолдолд байгууллагууд бүртгэлтэй загвараа ирүүлж болно. ARC нь хүсэлт ирүүлсэн байгууллагаас энэхүү загварыг нотолгоог илгээхийг шаардаж болно.

